

“АТАР-ӨРГӨӨ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 05 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

“АТАР-ӨРГӨӨ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурал 08.50 цагт Тооллогын комиссын бүртгэл ирцийн мэдээгээр 93% буюу нийт 163,975 ширхэг хувьцаатай 13 хувьцаа эзэмшигч хуралд оролцлоо. Үүнээс саналын хуудсаар санал ирүүлсэн хувьцаа эзэмшигч байхгүй байна.

Хурлын дарга Б.Мөнхдалай: Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. 2024 оны үйл ажиллагааг маш товчхон дурдъя. Бүх хувьцаа эзэмшигчид компанийн ерөнхий зүйлсийг мэдэж байгаа. 2024 оны компанийн ажилсан бүрэлдэхүүнийг дурдахад удирдлагын 8, дэд удирдлагын 5, захиргаа хүний нөөцийн 10, санхүү эдийн засгийн 11, үйл ажиллагаа, дотоод хяналтын 1, үйлдвэр технологийн 75, борлуулалт, маркетингийн 30, техникийн 2, чанар хяналтын 1 зэрэг албан нэгжүүдтэй удирдсан байна гэх мэт компанийн дотоод үйл ажиллагааг танилцуулж, хурлыг нээв.

ТУЗ-ийн аудитын хорооны гишүүн С.Бямбахорол: 2024 оны хараат бус, хөндлөнгийн аудитын дүгнэлтийг танилцуулав.

О.Баттулгын итгэмжлэгдсэн төлөөлөгч: Хязгаарлалттай дүгнэлт авсан байна. Энэ хязгаарлалттай дүгнэлт авсан шалтгаан, болон арилгах талаар ямар төлөвлөгөө гаргаж ажиллаж байгаа вэ?

ТУЗ-ийн аудитын хорооны гишүүн С.Бямбахорол: Хязгаарлалттай дүгнэлт хийх тухай хэлсэн. Энэ нь авлагын асуудал, эргэж төлөгдөх, эргүүлээд төлүүлэх зэрэг авлагын асуудал. Тэрнээс биш ямар нэгэн хууль тогтоомж зөрчсөн ч юм уу, бүртгэлийн стандарт зөрчсөн асуудлаас үүдсэн биш юм.

Хурлын дарга Б.Мөнхдалай: ТУЗ нь сүүлийн хоёр жил хүчингүй байсан тул ямар нэгэн шийдвэр гаргаж ажиллах боломжгүй байна. Энэ хурлын энэ дээр. Хэрэв хурал нь хүчин төгөлдөр болсон цагт арга хэмжээг авч ажиллах боломжтой.

С.Адьяасүрэнгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: Юу хэлэлцэх гээд байгааг сайн ойлгохгүй байна. Мэдээлэл өг.

Хурлын дарга Б.Мөнхдалай: Хөрөнгийн бирж болон арилжааны компаниуд дээр мэдээлэл нь байгаа. Хурлын дэгийн дагуу дараачийн асуудлаа ярья. Ноогдол ашиг хуваарилах тухай. Ноогдол ашиг хуваарилах эсэх асуудал нь ТУЗ-аас хуралдаж, шийдвэр гаргах ёстой байдаг. Харин сүүлийн жилүүдээс үүдэн ТУЗ нь зөвхөн хуралдах л эрхтэй байгаа тул энэ тал дээр ТУЗ нь хувьцааны ноогдол ашиг олгох шийдвэрийг гаргах боломжгүй байна. Хурлын дэгийг барьж, хурлын

асуудлыг л хэлэлцье. ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай хэлэлцэх нь зүйтэй. Юуны өмнө хурлаа хийгээд, ТУЗ-ийн ажлыг л хийлгэх хэрэгтэй байна зэргийг тайлбарлаж өгөв. Санал хураалтыг явуулъя. Бид хуулийн хүрээнд л ажлаа хийх ёстой.

Хувьцаа эзэмшигч Д.Мөнхтуяа: Хууль хяналтын байгууллагаас гарсан шийдвэр танилцуул, амаараа л яриад байгаа болохоос биш ямар нэгэн үзүүлэх шийдвэр байгаа бол үзүүл.

Хурлын дарга Б.Мөнхдалай: 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдөр манай компани шинэ жил хийх гэж байхад анхны энэ хувьцааны асуудлын эхлэл тавигдсан. Шүүхээс гарсан шийдвэрийн хүрээн СЗХ ажлаа хийх ёстой байсан. Бид ч энэ талаар холбогдох албан бичгүүдийг хүргүүлж байсан. Энэ маргаанаар ахиад Захиргааны хэргийн Улсын дээд шүүхийн шийдвэр ч сая гарсан. Хувьцааны саналын эрхийн маргааныг бид шийдэхгүй. Энэ маргааныг шүүх л эцэслэн шийднэ. Бид шууд саналын эрхтэй гэж шийдвэр гаргах эрх хуулиар олгогдоогүй. Саналын эрхгүй ч гэж дүгнэх эрх бидэнд байхгүй. Гагцхүү энэ маргааныг шүүхээр л эцэслэн шийдүүлэх нь зүйтэй юм. Бид энэ эрхийн маргааныг зогсоож ядаж ТУЗ-ийг ажилд нь оруулж, үйл ажиллагаагаа л жигдрүүлэх хэрэгтэй байна.

С.Адьяасүрэнгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: Та 2017 оны юм яриад байх юм. Миний хувьд 2023 онд 1 дүгээр сарын сүүлээр захиалгаа хийгээд хувьцаа худалдаж авсан. Би сүүлийн 2 жил энэ хуралд оролцож чадахгүй байна. Намайг саналын эрхтэй гэж Санхүүгийн зохицуулах хорооноос бичиг өгсөн. Би хувьцаа эзэмшигч мөн үү? Биш үү?

Хурлын дарга Б.Мөнхдалай: Би хууль бус гэж хэлээгүй.

С.Адьяасүрэнгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: Би бол мэргэжлийн хуульч хүн, Монгол Улсын Гавьяат хуульч хүн. Дээд шүүхийн юмыг буруу ойлгоод байх юм. Би одоо санал өгөх эрхгүй юм байна л даа. Хурлын дарга Б.Мөнхдалай: Энэ хурал саналын эрхтэй, эрхгүй талаар шийдэхгүй. Шүүх, хууль нь шийдэх асуудал.

С.Адьяасүрэнгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: Намайг хорооноос эрхтэй гэж бичиг хийж өгсөн.

О.Баттулгын итгэмжлэгдсэн төлөөлөгч: Шүүхийн шийдвэр дээр саналын эрхгүй гэж дүгнээгүй.

Хурлын дарга Б.Мөнхдалай: Тиймээ шүүх дүгнээгүй. Энэ маргааныг Иргэний шүүхээр эцэслэн шийдвэрлүүл л гэж хэлсэн. Иймд Иргэний шүүхээр нь л эцэслэн шийдвэрлүүлэх хэрэгтэй юм аа. Хуралд хамаагүй асуудлыг жич ярина. Одоо хуралд хэлэлцэх асуудлыг л ярина. Санал хураалт.

С.Адьяасүрэнгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: Би санал аа өгнө. Эрхтэй гэж дүгнэ. Миний эрх ашгийг зөрчөөд байна.

Хурлын дарга Б.Мөнхдалай: Энэ эрхийг би дур мэдээд өгч чадахгүй, болохгүй. Энэ талаар нотлох баримтаа хангаад шүүхээр шийдүүлсэн нь хамгийн зөв байна.

Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын хорооны гишүүн

С.Халиун: Өнөөдөр би энэ хурал дээр жижиг хувьцаа эзэмшигч нарын гомдлоор ирж оролцож байна. Хувьцаа нь объект юм. Саналын эрхгүй хувьцаа нь хэн худалдаж авсан эсэхээр тодорхойлогдоно. Хяналтын багцын худалдаж авсан Тендерийн тухай хуулиар, эсвэл нэгдмэл сонирхолтой этгээд худалдаж авсан тохиолдолд саналын эрхгүй болно. Баттулга, Адьяабазар нар нь субъект өөр тул энэ тал дээр хамаарахгүй. 2019 оны шүүхийн шийдвэр бол хамаарахгүй. Үндсэн хуулиар Эрүүгийн зарчим бий. Нотлогдоогүй бол гэм буруугүй гэдэг зарчим бий. Энэ зарчим шиг Улаанбаатар гурилтай энэ этгээдүүд нь хамаагүй гэдгийг нотлоогүй байж саналын эрхтэй. Саналын эрхээ алдсан гэдгийг Санхүүгийн зохицуулах хороо тодорхойлдог. Ямар шүүхийн шийдвэрээр энэ хүмүүсийг саналын эрхгүй гээд байгаа вэ?

Хурлын дарга Б.Мөнхдалай: Би бол энэ хүмүүсийн талд байгаа. 2022 оны шүүхийн шийдвэрээр Таванбогд инвест-д байгаа хувьцаа нь саналын эрхгүй гэж шийдсэн. Саналын эрхгүй хувьцааны хөдөлгөөнийг Санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалт хийх байсан. Би Санхүүгийн зохицуулах хорооны ажлыг хий гээд шаардаж чадахгүй. Ажлын хүрээнд зохицуулалт хийх байсан ч хийгээгүйн улмаас энэ хүмүүст ч давхар хамаараад явчхаж байгаа юм. Би хувьцаа зараагүй, шийддэг газраар нь шийдүүлэх хэрэгтэй. Бид нар эрхтэй гэж хэлж чадахгүй, эрхгүй гэж хэлж чадахгүй. Дараагийн асуудлыг хэлэлцэх хэрэгтэй байна.

Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын хорооны гишүүн

С.Халиун: Компанийн тухай хуулиар тодорхой зохицуулалт байгаа. Саналын эрхтэй, эрхгүй гэдгийг тооллогын комисс яаж дүгнэж байгаа вэ гэдгийг сайн тусгаж өгөөрэй.

Хувьцаа эзэмшигчид: Маргаан гарж байна.

Хурлын дарга Б.Мөнхдалай: Шүүх дээрээ л энэ талаар шийдүүлэх хэрэгтэй шүү дээ. Энэ хурал нь хууль гаргадаг газар биш. Шийддэг эрх бүхий л газраар л шийдүүлэх хэрэгтэй. Хуралд хамаагүй асуудлыг зогсооё. Дараагийн хурлын асуудалд орно.

Хувьцаа эзэмшигч: Маргаан гарж байна...

Хурлын дарга: Маргааныг өндөрлүүлж санал хураалтаа явуулцгаая.

Санал хураалт явагдаж, саналын хуудсыг бөглүүлэхээр 10.00 цагт хурлыг завсарлав хэрхэн бөглөх талаар тайлбар өгөв.

Саналын хуудсыг хураан авч, тооллогын комисс дүнгээ танилцуулахаар бэлтгэв.

10.20 Санал хураалтын дүн танилцуулж, ТУЗ-аас сонгогдсон гишүүдийн нэрсийг танилцуулж байна.

Тооллогын комиссын дарга Ц.Энхтүвшин: Санал хураалт явагдаж дууслаа. Дүнгээр Мөнхдалай, Ганбат, Сайнбилэг, Энхболд, Мөнхтэнгис,

Баттулга нар ердийн гишүүдээр, Жигмэддагва, Бямбахорлоо, Болормаа нар тус тус хараат бус гишүүдээр томилогдсон байна.

Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах- Зөвшөөрсөн 88,032, татгалзсан 27,

Компанийн санхүүгийн тайлан, хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулж, батлах- Зөвшөөрсөн 88,024, татгалзсан 35,

Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулж, хэлэлцэн батлах- Зөвшөөрсөн 88,024, татгалзсан 35,

ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын дүнг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийг батлах- Зөвшөөрсөн 88,032, татгалзсан 27 гэснээр санал хураалтын дүн гарч, хурал 10.30 цагт өндөрлөв.

ХУРАЛ УДИРДСАН

Б.МӨНХДАЛАЙ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

Б.ХАНХҮСЛЭН